

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	4
2	Аудитын тайлан.....	6
2.1.	Оршил.....	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	7
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	9
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.8.1	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3	Менежментийн захидал.....	15
3.1	Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний тухай.....	15
3.1.1	Илрүүлэлт:.....	15
3.1.2	Эрсдэл:.....	15
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	15
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	16
3.2	Бараа материалын худалдан авалттай холбоотой асуудал.....	16
3.2.1	Илрүүлэлт:.....	16
3.2.2	Эрсдэл:.....	16
3.2.3	Өгсөн зөвлөмж:.....	16
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	16
3.3	Хүнсний бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал.....	16

3.3.1 Илрүүлэлт:	16
3.3.2 Эрсдэл:.....	16
3.3.3 Өгсөн зөвлөмж:.....	16
3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	17
3.4 Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай асуудал.....	17
3.4.1 Илрүүлэлт:	17
3.4.2 Эрсдэл:.....	17
3.4.3 Өгсөн зөвлөмж:.....	17
3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	17
3.5 Касс дахь бэлэн мөнгөтэй холбоотой асуудал	17
3.5.1 Илрүүлэлт:	17
3.5.2 Эрсдэл:.....	17
3.5.3 Өгсөн зөвлөмж:.....	17
3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	18
4 Байгууллагаас ирүүлсэн санхүүгийн тайлан	19
4.1 Байгууллагаас ирүүлсэн Санхүүгийн байдлын тайлан	19
4.2 Байгууллагаас ирүүлсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	21
4.3 Байгууллагаас ирүүлсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.4 Байгууллагаас ирүүлсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	24
5. Хавсралт	26
5.1 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“СПОРТ БЭЛТГЭЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ О.БАЯРБАТ
ТАНАА

2019.03.20 № 06/529
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан дахь бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн данснуудын оны эхний үлдэгдэл 1,314.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,102.0 сая төгрөгийг баталгаажуулах хангалттай бөгөөд зохистой нотолгоо байхгүй. Авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт, нотлох баримт байхгүй байгаа нь оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна. Мөн бараа материал, үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүйн улмаас бид тооллогын ажиглагчаар оролцоогүй нь дээрх хөрөнгүүдийн оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Засгийн газрын 2016 оны 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалын дагуу үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй байгаа нь аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.
- Бараа материалын худалдан авалтын 66.9 сая төгрөгийн баримтууд нь хүчин төгөлдөр бус, хүнсний материалын зарцуулалтад хяналт тавьдаггүй, худалдан авалтын дүнгээр шууд зардлыг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Үйл ажиллагааны 29.5 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу тусгасан.
- 2018 оны тайлант хугацаанд үндсэн ажилтнуудад тооцсон цалинг бүрэн олгоогүй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гаргаагүй, өртэй гэсэн шалтгаанаар нийгмийн даатгалын хэлтэст тайлагнаж баталгаажуулаагүй байна.

Үүрэг, хариуцлага

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын захирал О.Баярбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 21-нээс 2019 оны 3 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Сарантуяа, Л.Мөнхцэцэг, аудиторын туслах М.Нямсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ газар нь 2018 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/84 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь байгууллагын дүрэм бусад эрх зүйн актаар Эрхэм зорилгоо тодорхойлж баталгаажуулаагүй. Харин байгууллагын хэвлэмэл танилцуулгад “Монгол Улсын биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулалтыг хийхэд ая тухтай нөхцөл бололцоогоор хангах, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд байгууллагын эрхэм зорилго оршино” гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний шигшээ багийн бэлтгэл цугларалтыг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг хангах.
- Үндэсний шигшээ багийн бэлтгэл цугларалтыг зохион байгуулахад үйлчилгээ үзүүлэх.
- Спортын хороо, клубын захиалгаар бэлтгэл цугларалтыг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх.
- Иргэдэд амралтын үйлчилгээ үзүүлэх.
- Спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих хамтарч ажиллах.
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Хууль тогтоомжоор хориглоогүй бусад аж ахуйн ажиллагаа хэрэглэх.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Биеийн тамир спортын тухай хууль

Тайлант хугацаанд “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын мөрдөж ажилладаг бодлого, журамд ямар нэгэн шинэчлэлт өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчиж байна.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл

ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын нягтлан бодогч нь 2018 оны хагас жилийн санхүүгийн тайланг эксел хүснэгтээр бэлтгэсэн байна. Сүүлийн хагас жилийн санхүүгийн тайланг Эрдэнэт хот дахь “Мэйжик Чойс” ХХК-д хандан тус компанийн тооцоолон бодох экселд суурилсан программыг ашиглан гаргуулсан байна.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгов.

Энэ нь цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь цэвэр хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад бусад нийт орлого болон зардлын дүн хэт бага байгаатай холбоотой юм.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2018 оны цэвэр хөрөнгө 800.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдлийг өндөр гэж тооцсонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд эдгээр 9 асуудал нь бүгд алдаа, зөрчилтэйд тооцогдож байна гэж үзлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Нийт 29.5 сая төгрөгийн харилцагчаас орж ирсэн орлогыг орлого үр дүнгийн тайланд дутуу тусгасан.
- Санхүүгийн тайланд 2.9 сая төгрөгийн нэмүү өртгийн албан татварын өглөгийг дутуу тусгасан.
- Санхүүгийн тайланд тусгагдсан 32.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч залруулав.
- 2017 оны нийгмийн даатгалын шимтгэлийн эцсийн үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр дутуу тусгагдсаныг нөхөж тусгав.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	1,088.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	4	186.7	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	9	1,274.8	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Үндсэн хөрөнгийг капиталжуулаагүй

Улсын төсвийн хөрөнгөөр барилга байгууламжид хийгдсэн 73.0 сая төгрөгийн их засварыг санхүүгийн тайланд тусгаж капиталжуулаагүй

Шийдэл:

Албан шаардлага хүргүүлсэн.

Асуудал 2: Авлага, өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй.

2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт 15.0 сая төгрөгийн авлага, 98.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Цалингийн өглөг нэрээр байгаа 33.1 сая төгрөг нь ажилтны нэрээр задраагүй байна.

Шийдэл:

Албан шаардлага хүргүүлсэн.

Асуудал 3: 2018 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдэл:

Албан шаардлага хүргүүлсэн.

Асуудал 4: Шилэн дансны мэдээлэл

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТ нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.6, 6.2.1-6.2.6, 6.3.1-6.2.9, 6.4.1-6.4.9-д заасан оруулбал зохих 30 мэдээллээс огт мэдээлэл оруулаагүй байна.

Шийдэл:

Албан шаардлага хүргүүлсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нэг. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

- 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн амралтын байрны их засварын бодит гүйцэтгэлийг үндсэн баримттай тулгаж санхүүгийн тайланд капиталжуулсан эсэхийг шалгах.
- “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын амрагчдад өгч байгаа хоолны хүнсний материалын орц зарцуулалтыг хоолны меню болон хүнсний технологийн картыг үндэслэн тооцоолсон эсэх.
- 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан авлага өглөгийн дүнг тулган баталгаажуулалт хийсэн эсэх.
- Үндсэн хөрөнгө бараа материалын тооллого хийхэд ажиглагчаар оролцож үр дүнг санхүүгийн тайланд тусгахад хяналт тавих.

Хоёр. Ажиглагдсан анхаарал татсан бусад асуудлууд:

- Тус төв нь тамирчид болон амрагчдыг хүлээж авах боломжтой дулааны улирал буюу 5-аас 10 дугаар сарын хооронд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бусад үед байгууллагын үйл ажиллагааг бүрэн зогсоож зөвхөн манаач амралтын газар үлддэг байна. Гэтэл тус төвийн бусад үндсэн ажилтнууд болох захирал, нярав, нягтлан бодогчид бүтэн жилийн турш үндсэн цалингаа бүтнээр тооцон цалингийн өглөг үүсгэн санхүүгийн тайланд тусгаж байна. “Спорт бэлтгэлийн төв”-ийн дүрэм болон

дотоод журамд байгууллага үйл ажиллагаа явуулаагүй байгаа хугацаанд ажилтнуудын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр эсвэл бодит ажилласан цагаар нь тооцож олгох тухай ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй байна. Энэ байдал нь 2016 оноос эхлэн үргэлжилж байгаа бөгөөд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 33.1 сая төгрөгийн цалингийн өглөг, 29.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг хуримтлагдаад байна. Энэ нь компанийн санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн орлого зарлагын уялдаат зарчмыг хангахгүй байна.

- Ажлын оргил үе буюу дулааны улиралд ажиллаж буй түр ажилтнуудтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулдаггүй, цалингаас тооцсон хувь хүний орлогын албан татварыг татварын албанд тайлагнаагүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-д хүргүүлээгүйгээс 2017 оны санхүүгийн тайланд Татгалзсан дүгнэлт өгөгдсөн. Үүнтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны гэрээг дүгнээгүй мөн 2018 оны зорилтот түвшинг баталгаажуулаагүй байна.

2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь 2018 оны тайлант жилд 88,2 сая төгрөгний борлуулалтын орлого олж 188.3 сая төгрөгийн зардал гаргаж 100.1 сая төгрөгний алдагдалтай ажилласан байна. “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын орлогыг 100 хувь тус төвд бэлтгэл хийсэн тамирчид болон амрагчдын байр хоолны төлбөр бүрдүүлж байна. Зардлын нийт бүрэлдхүүнд голлох хувь эзлэх зардлын нэр төрлийг авч үзвэл үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 33.1 хувь бэлтгэлийн төвийн байрны ус цахилгаан зэрэг ашиглалтын зардлыг хугацаанд нь төлөөгүйгээс үүссэн хүү торгуулийн зардал 13.3 хувь, амрагч үйлчлүүлэгчдийн хоолны хүнсний материалын зардал 18.2 хувь, ажилчдын цалингийн зардал 14.8 хувийг тус тус эзэлж байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 6.1.1-6.1.6, 6.2.1-6.2.6, 6.3.1-6.2.9, 6.4.1-6.4.9-д заасан нийт 30 мэдээлэл оруулахаас нэг ч мэдээлэл оруулаагүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн жилд нягтлан бодогчгүй гэсэн шалтгаанаар санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй учраас Эйч Эл Би Монголиа Аудит ХХК “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд Татгалзсан дүгнэлт өгсөн тул ямар нэгэн зөвлөмж гараагүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний тухай

3.1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу “Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь барилга байгууламжид дахин үнэлгээ хийгээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга тодруулга гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь барилга байгууламжуудын дахин үнэлгээг Сангийн сайдын 207 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж мэргэжлийн үнэлгээний байгууллагаар хянаж баталгаажуулах. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг санхүүгийн тайланд тусгах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу дахин үнэлгээ хийлгүүлнэ.

3.2 Бараа материалын худалдан авалттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Хүнсний захын лангуу түрээслэгч болон бусад хувь хүнээс бэлэн мөнгөөр худалдан авсан амрагчдын хоол хүнс болон цэвэрлэгээний материалын нийт 66.9 сая төгрөгийн зарлагын падаанууд нь татвар төлөгч хувь хүний татварын баталгааны тэмдгээр баталгаажаагүй, худалдан авалтын дүнг суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайланд тусгаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хүчин төгөлдөр бус баримт бүхий худалдан авалтын дүнгээс татварын нөхөн төлбөрийн өглөг үүсэх. Бараа материалын худалдан авалт батлагдахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хүнсний болон бусад хангамжийн бараа материалыг татвар төлөгч баталгаат бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авч холбогдох татварын тооцоог тухай бүр хийж байх, татвар төлөгчөөр бүртгэгдээгүй зарим иргэдээс хүнсэнд хэрэглэх мах сүү байнга худалдан авах бол гэрээ хийж худалдан авалтын дүнг татварын тайланд тусгаж байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

3.3 Хүнсний бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Амрагчдын өдөр, оройн хоолонд зориулан хүнсний материалыг тавьж олгохдоо хүнсний технологийн картын дагуу хэрэглээг тооцдоггүй, амрагчдад бэлтгэсэн хоолны меню байхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Хүнсний материалын зүй бус зарцуулалт гарах.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Амрагчдад хүнс, хоолоор үйлчлэхдээ өдөр тутмын хоолны менюг захирал болон ахлах тогоочоор батлуулан хүнсний технологийн картын дагуу материалын хэрэгцээг тооцон тогоочид олгож байх. Хүнсний материалын хорогдлыг тооцож байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

3.4 Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай асуудал

3.4.1 Илрүүлэлт:

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ нь 2018 оны 2 дугаар сараас хойш нийгмийн даатгалын шимтгэлийн 29.1 сая төгрөгийн хуримтлагдсан өрийг төлж чадахгүй байгаагаас тайлангаа нийгмийн даатгалын хэлтэст тушааж баталгаажуулаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж өглөгийг барагдуулаагүй учраас торгууль оногдох, ажилтнуудын төлсөн нийгмийн даатгал системд бүртгэгдээгүйгээс нийгмийн даатгалын байгууллагаас олгох төрөл бүрийн хөнгөлөлт эмнэлэгийн үйлчилгээ мөн тэтгэмжүүд авч чадахгүй байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын өглөгийг барагдуулж тайланг баталгаажуулах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

3.5 Касс дахь бэлэн мөнгөтэй холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ-ын бэлэн мөнгөний кассын дэвтэр, журнал хөтлөлт хангалтгүй, амрагчдын бэлнээр тушаасан орлогын ордерт хэдэн хүн хэд хоногоор амарсан тухай тодорхойлж бичдэггүй, кассын мөнгөний тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулдаггүй, кассын гүйлгээнд бүртгэлээр тавих хяналт сул нийт 0.7 сая төгрөгийн кассын орлогын баримт байхгүй, кассын орлого зарлагын баримтууд дугааргүй, захирал нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулагдаагүй.

3.5.2 Эрсдэл:

Кассын мөнгөнд бүртгэлээр тавих хяналт сул, мөнгөн хөрөнгийн зүй бус зарцуулалт гарах.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Кассын орлого зарлагын ордерийг дугаарлаж анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, сар бүрийн эцэст кассын үлдэгдлийг тоолж баталгаажуулж байх, хүнсний болон бусад бараа материалыг бэлэн мөнгөөр худалдан авах тохиолдолд урьдчилгаа олгож эргэж тооцоо хийж байх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 06-р сарын 30-ны дотор Эйч Эл Би Монголиа Аудит ХХК болон Үндэсний аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Байгууллагаас ирүүлсэн санхүүгийн тайлан

4.1 Байгууллагаас ирүүлсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	382,878.80	1,230,868.85
1.1.2	Дансны авлага	273,750.00	15,023,750.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	31,428,495.50	32,855,796.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	32,085,124.30	49,110,414.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,009,495,663.63	955,469,001.21
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,009,495,663.63	955,469,001.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,041,580,787.93	1,004,579,416.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	61,583,129.45	78,743,798.00
2.1.1.2	Цалингийн өглөг	29,418,406.47	33,065,630.50
2.1.1.3	Татварын өр	6,077,637.60	25,146,811.96

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.4	НДШ–ийн өглөг	22,164,743.86	29,108,109.34
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		690,451.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		7,983,700.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	119,243,917.38	174,738,500.80
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	119,243,917.38	174,738,500.80
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,163,939,288.84	1,172,141,788.84
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(241,602,418.29)	(342,300,873.58)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	922,336,870.55	829,840,915.26
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,041,580,787.93	1,004,579,416.06

4.2 Байгууллагаас ирүүлсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	121,135,495.35	88,150,454.55
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)		
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		146,506,886.62
10	Ерөнхий ба удирдлагын зардал	174,983,790.81	16,559,500.91
11	Санхүүгийн зардал		25,241,767.00
12	Бусад зардал	3,868,060.00	3,363.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(57,716,355.46)	(100,161,063.62)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(57,716,355.46)	(100,161,063.62)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(57,716,355.46)	(100,161,063.62)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Байгууллагаас ирүүлсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриглагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,163,939,288.84						(183,886,062.83)	980,053,226.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	1,163,939,288.84						(183,886,062.83)	980,053,226.01
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							(57,716,355.46)	(57,716,355.46)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,163,939,288.84						(241,602,418.29)	922,336,870.55

“Спорт бэлтгэлийн төв” ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						(537,391.67)	(537,391.67)
11	Залруулсан үлдэгдэл	1,163,939,288.84					(242,139,809.96)	921,799,478.88
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						(100,161,063.62)	(100,161,063.62)
13	Бусад дэлгэрэнгүй орлого							
14	Өмчид гарсан өөрчлөлт	8,202,500.00						8,202,500.00
15	Зарласан ногдол ашиг							
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
17	2018 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	1,172,141,788.84					(342,300,873.58)	829,840,915.26

4.4 Байгууллагаас ирүүлсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	104,911,745.00	82,905,951.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	104,911,745.00	82,905,951.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		951.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	104,573,248.00	82,057,960.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	24,228,660.00	19,195,013.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	43,124,964.00	43,921,604.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,272,710.00	1,512,315.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,072,014.00	6,111,439.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	14,874,900.00	11,317,589.95
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	338,497.00	847,990.05
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	338,497.00	847,990.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	44,381.80	382,878.80
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	382,878.80	1,230,868.85

5. Хавсралт

5.1 Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Аудитын нэр:	"Спорт бэлтгэлийн төв" ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.11		САГ-2019/92/СТА- ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	"Спорт бэлтгэлийн төв" ТӨААТҮГ	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Бараа материалын худалдан авалттай холбоотой анхан шатны баримт хүчин төгөлдөр бус. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна	66.9	Зөвлөмж өгөх	Захирал	О.Баярбат
2	Кассанд хүлээн авсан орлогын иж бүрдэл дутуу анхан шатны баримт үйлдээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй	0.7	Зөвлөмж өгөх	Захирал	О.Баярбат

	ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна				
3	2018 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын тайлан гаргаж тайлагнаагүй, өр төлбөрийг барагдуулаагүй.	29.1	Зөвлөмж өгөх	Захирал	О.Баярбат
4	Засгийн газрын 2016 оны 193 тоот тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалын дагуу үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийлгүүлэх.	955.5	Зөвлөмж өгөх	Захирал	О.Баярбат
5	Хүнсний материалаар амрагчдын хоол бэлдэхдээ батлагдсан технологийн карт мөрддөггүй шууд зарцуулалт хийдэг.	36.0	Зөвлөмж өгөх	Захирал	О.Баярбат
6	Авлага 15.0 сая төгрөг, өглөг 98.7 сая төгрөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	113.7	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	О.Баярбат
7	Үндсэн хөрөнгийн их засварыг капиталжуулаагүй байна.	73.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	О.Баярбат
8	2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй байна.	0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	О.Баярбат
9	Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-6.1.6, 6.2.1-6.2.6, 6.3.1-6.2.9, 6.4.1-6.4.9-д заасан нийт 30 мэдээлэл оруулахаас мэдээлэл оруулаагүй байна.	0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал	О.Баярбат
	Нийт дүн	1,274.9			

